

улс Хятад, ОУВС-гаас санхүүгийн тусламж авахаар хэлэлцэж буй, зарим хөрөнгө оруулагч дээрх хугацаанаас өмнө талууд зөвшилцөлд хүрч амжихгүй байж магадгүй гэж үзэж байгааг дурджээ. Одоогоор Монгол Улсын зээлжих зэрэглэл Саал байгаа юм. “Moody's” агентлаг манай улсын зээлжих зэрэглэлийг өнгөрсөн оны арваннэгдүгээр сард В3-аас эрсдэлтэй ангилалд оруулсан билээ. Тус агентлаг мэдэгдэлдээ “Монгол Улс бондын төлбөрөө ойрын хугацаанд хэрхэн хийх нь хараахан шийдэгдээгүй байгаа” хэмээн дурджээ. Монгол Улсын Засгийн газрын холбогдох хүмүүс бондын төлбөрийг хугацаанд нь төлөхийг мэдэгдэж буй.

УУЛ УУРХАЙ

“Kincora corper” хоёр цэгт өрөмдлөг хийх нь

Торонтогийн “Venture” хөрөнгийн биржид бүртгэлтэй “Kincora corper” компани ирэх зургаан сард хоёр өрөмдлөг хийхээр төлөвлөжээ. Тодруулбал, Баянтал, Зүүн Цагаан суварга талбайд өрөмдлөг хийх аж. Уг хоёр талбайд Оюутолгой, Цагаан суваргатай төстэй орд байж магадгүй хэмээн үзэж буй юм. Тус компанийн ерөнхийлөгч бөгөөд гүйцэтгэх захирал Сэм Спринг “Зорилтот цэгүүдэд өрөмдлөг хийснээр өндөр агууламж бүхий нөөц илрүүлэх боломж бий гэж үзэж байгаа” хэмээн өгүүлжээ. Дээрх мэдээллийн дараа “Kincora corper”-ын хувьцааны ханш 1.1 хувиар дээшилж, нэгж нь 0.46 канад доллартой тэнцэв. Тус компани манайд “Оюут Улаан”, “Хүрэл үнэг” төсөл мөн хэрэгжүүлдэг.

ШҮҮХИЙН ТАНХИМААС

Хүүхэд барьцаалсан залууг долоон жил хорихоор боллоо

Хүүхэд барьцаалсан Б.Мөнхбаярт холбогдох хэргийг өчигдөр Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх хэлэлцлээ. Тэрбээр өнгөрсөн оны аравдугаар сарын 21-нд 16 настай Б-д цаасны хутга тулган барьцаалж, улмаар аав руу нь утсаар “3-4 цагийн дотор 80 сая төгрөг авчирч өгөхгүй бол хүү чинь үхнэ, гэр бүлийнхэн чинь ч миний барьцаанд байгаа” хэмээн сүрдүүлсэн хэрэгт холбогдсон юм. Баянгол дүүргийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн 112-т заасан “Шунахайн сэдлээр, хохирогчийн амь биед заналхийлж, зэвсгийн чанартай зүйл ашиглан бага насны хүүхэд барьцаалсан” гэсэн үндэслэлээр Б.Мөнхбатад яллах дүгнэлт үйлдсэн. Анхан шатны шүүхээс түүнийг гэм буруутайд тооцон долоон жил хорих ял оноолоо.

ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРАЛ

Эрдэмтэд 270 дугаар тогтоолыг хүчингүй болгохыг шаардав

Ж.СУВЛМАА

тухай мэдээлэл ирсэн.

Гадаад харилцааны яамны Консулын газар дээрх иргэдийн ар гэрийнхэнтэй холбогдон мэдээлэл өгсөн. Эрээн хотод суугаа Консулын

байдлаар 36 иргэн БНХАУ-д, нэг хүн Словакт ял эдэлж байна. Он гарсаар мансууруулах бодис зөөсөн хэрэгт БНХАУ-д гурав, ОХУ-д нэг хүн саатуулагдсан байна. Харин Малайз улсад

Өнгөрсөн мягмар гаригт ч бас хоёр залуу мансууруулах үйлчилгээтэй өвс тээвэрлэж яваад баригдсан юм.

ӨДРИЙН СУРВАЛЖИЛГА

Сургууль орчимдоо аюулгүй зорчих боломжтой болох нь



Э.ХАРИАГА FOCUS

Ч.БОЛОРТУЯА

Цүнхээ үүрээд хичээлдээ явсан хүү ангийнхантайгаа, гэр бүлийнхэнтэйгээ хэзээ ч дахин уулзахгүйгээр хорвоогоос буцна гэдэг ямар аймшигтай вэ. Ийм аймшигтай мэдээг жилд 50 гаруй хүүхдийн эцэг, эх сонсож, 1000 орчим хүүхэд зам, тээврийн ослын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болж байна. Нийслэлд ерөнхий боловсролын 209 сургууль үйл ажиллагаа явуулдаг зам, тээврийн осол гарах эрсдэлтэй орчинд байдаг нь 100 гаруй. Тэдгээрийн нэг Чингэлтэй дүүргийн V сургууль. Тус сургуулийн гурван

талд авто зам байдаг ч гэрэл дохио огт үгүй. Өнгөрсөн жил энэ сургуулийн есөн сурагч зам, тээврийн осолд өртөн гэмтжээ. Тиймээс Австрали улсад суралцаж төгссөн таван монгол эмэгтэй Замын цагдаагийн албатай хамтран “Зам, тээврийн осолгүй сургууль” гэсэн төсөл тэнд хэрэгжүүлэхээр болсон аж. Төслийн хүрээнд V сургуульд замын хөдөлгөөний аюулгүй байдлын жишиг танхим байгуулж, сургууль орчимд хоёр гэрэл дохио, 62 метрийн урттай хурд сааруулагч тав, тэмдэг тэмдэглэгээ, хайс 34 ширхгийг байрлуулах аж. Үүнд 40 гаруй сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн бөгөөд үүний талыг

Австрали улсын Засгийн газраас гаргахаар болсон байна. Харин үлдсэнийг нь Монголын компаниудаас “босгох”-оор төлөвлөжээ. Төслийг санаачлагчдын нэг М.Эрдэнэчимэг “Австралид хүүхдүүд сургууль орчимдоо зам, тээврийн осолд өртдөггүй. Гэр нь хэр хол буйгаас шалтгаалж сурагчдыг автобусаар зөөдөг, нийтийн тээвэрээр тэд үнэгүй зорчдог, сургууль орчимд жолооч нар хурд хэтрүүлэх ямар ч боломжгүй. Учир нь сургууль орчмын 200 метрийн зайд тээврийн хэрэгслийг 40 км/ц хурдтай явахаар хуульдаа зохицуулсан байдаг юм. Хэрэв энэ бүсээр хурд хэтрүүлэх юм бол энгийн газар дүрэм зөрчсөнөөс хоёр дахин илүү төлбөр төлдөг” гэв. Харин Замын цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах хэлтсийн дарга, хурандаа Э.Бөхбат “Хүүхэд зам, тээврийн осолд өртөж буй нэг нөхцөл нь сургуулийн орчин. Автозамд ойр сургуулиудын орчимд гэрэл дохио байрлуулж, хурд сааруулагчтай болгосноор сурагчид осолд өртөхгүй байгаа. Тиймээс аль болох зам, тээврийн осолгүй сургуулийн тоог нэмэгдүүлэх хэрэгтэй” гэсэн юм. Тус сургуулийн тавдугаар ангийн сурагч хүү “Өвөл харанхуйд зам гарахаас айдаг. Машиныуд маш хурдан давхидаг” гэв. “Эцэг, эхчүүд бид өөрсдөө жолооч. Тиймээс хүүхэд зам гарч байхад хурдаа сааруулж, зогсох соёлд сурах хэрэгтэй. Мөн замаар хэрхэн аюулгүй зорчих мэдлэгийг хүүхдүүдэд сургалтаар дамжуулан олгоно” гэж төслийг санаачлагчид хэлэв. Төслийг тавдугаар сарын 1 хүртэл хэрэгжүүлэх бөгөөд 3000 орчим сурагч сургууль орчмынхоо замд аюулгүй зорчих боломжтой болох нь.

“Монгол ньюс” ахмадуудаа хүлээн авав



Ц.УНДРАЛ

“Монгол ньюс” компани Сар шинийн

эрхлэгч асан, Соёлын гавьяат зүтгэлтэн Б.Лингдэн, орлогч эрхлэгч асан, Соёлын гавьяат зүтгэлтэн Б.Пүрэвдаш, Ардын уран

Соёлын гавьяат зүтгэлтэн Р.Чулуун, одоо тоймчоор ажиллаж буй Соёлын гавьяат зүтгэлтэн И.Рэнчинханд тэргүүтэй төлөөлөл ирсэн юм. Энэ үеэр Д.Цоодол бусад урилгыг хүлээн аваагүй ч “Өнөөдөр” сонины хамт олноо зорин ирснээ хэлж байв. Мөн Р.Чулуун “Уулзалт гэдэг дурсамж юм. Бид энд уулзаж байгаа нь Ц.Балдорж хэмээх эрхэм дүүтэй мянган сэжмээр холбоотой. Хуучин танилуудтайгаа уулзаж байгаадаа баяртай байна” хэмээн өгүүлсэн. Нэгнээ харахаар дурсамжууд шууд л санаанд орж байна хэмээн дурсдаг ахмадуудыгаа “Монгол ньюс” компани жил бүр хүлээн авдаг билээ. Ахмадууд маань өөдрөг, сайхан байна гэдэг нь “Монгол ньюс”-ийнхний ажил үйлс